

**“Экономиксийн цагаан толгойг хэн сайн мэдэх вэ?”**

Улсын X олимпиад I шатны тест

2013. 05. 05

Хугацаа: 50 минут

1. Микроэкономиксийн судлах зүйл нь
  - A. Тухайн улсын эдийн засгийн хөгжлийн ерөнхий зарчмыг илэрхийлнэ
  - B. Эдийн засгийн хөгжлийн хууль эрх зүйн орчныг тодорхойлно
  - C. Анхдагч түвшинд эдийн засгийн шийдвэрийг хэрхэн гаргахыг харуулна
  - D. Үндэсний хэмжээнд эдийн засгийн шийдвэр хэрхэн гаргахыг харуулна.
2. Микроэкономикс нь судлах зүйлийн хувьд макроэкономиксоос юугаараа ялгаатай вэ?
  - A. Зөвхөн үйлдвэрийн газраар хязгаарлагддаг
  - B. Зөвхөн өрхийн доторх үйл хөдлөлийг судалдаг.
  - C. Зөвхөн улсын хэмжээний үйлдвэрлэлийг судалдаг
  - D. Зөвхөн анхдагч түвшний субъектуудын үйл хөдлөлийг судалдаг
3. Дорж, Бат, Дондог нар хамтарч өрхийн үйлдвэрлэл явуулдаг. Нэг сард Дорж 25 том сандал эсвэл 30 жижиг сандал, Бат 21 том сандал эсвэл 35 жижиг сандал, Дондог 15 том сандал эсвэл 30 жижиг сандал хийдэг. Дараах хариултуудад том, жижиг сандлуудын харьцаагаар илэрхийлэгдсэн тус бүр 2 цэг өгөгджээ. Эдгээрээс аль нь өрхийн үйлдвэрлэлийн боломжийн хязгаарын муруй дээр орших вэ
 

A. 25: 65;	46 :30	C. 0:61;	39:28
B. 29: 47;	45:20	D. 30: 60;	61: 35
4. Хэрвээ үйлдвэрлэлийн боломжийн муруй гүдгэр бол “?” байранд
 

Машин	Сонин	A. 340
10	400	B. 330
12	360	C. 320
14	?	D. 310
5. Алдагдсан боломжийн зардал нь
  - A. Ямар нэгэн зүйлд хэр зэрэг мөнгө зарцуулснаар
  - B. Ямар нэгэн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хэр цаг хугацаа зарцуулснаар
  - C. Хийсэн сонголтын дараах хамгийн сайн сонголтын үр ашгийг
  - D. Дээрх бүгд зөв
6. Зах зээлийн эрэлтийн функц  $Q_d = 60 - aP$  гэж өгөгдсөн ба орлогыг хамгийн их байлгах үнэ 3 бол  $a$ -ийн утгыг ол
 

A. 3	B. 8	C. 10	D. 15
------	------	-------	-------
7. Тухайн барааны эрэлтийн функц  $Q_d = 50 - P$  ба нийлүүлэлтийн функц  $Q_s = -10 + 3P$  байв. Хэрэв энэ барааны үйлдвэрлэгчийн үнэд 8 төгрөгийн татвар оногдуулсан бол хэрэглэгч ба нийлүүлэгчид ноогдох татварын ачаалал харгалзан
 

A. 6 ; 2	B. 5 ; 3	C. 4 ; 4	D. 3 ; 5
----------	----------	----------	----------
8. Доорх хүснэгтийг ашиглан үйлдвэрлэлийн өргөжилтийн тогтмол үр өгөөжтэй пүүсийг тодорхойл.
 


Пүүсүүд	Үйлдвэрлэгдсэнбүтээгдэхүүн	
	K=100, L=20	K=150, L=30
A	29.9	44.9
B	94.6	157
C	14.1	19.2

A. A	C. C
B. B	D. Аль нь ч биш
9. Хэрэв үйлдвэрлэгч богино хугацаанд бүтээгдэхүүн огт үйлдвэрлэхгүй байгаа бол нийт зардал нь
 

A. Тэгтэй тэнцүү	C. Хувьсах зардалтай тэнцүү
B. Тогтмол зардалтай тэнцүү	D. Ахиу зардалтай тэнцүү
10. Аливаа хөрөнгийн өнөөгийн үнэ цэнэ ирээдүйн үнэ цэнэтэйгээ тэнцүү бол бодит зээлийн хүү
 


A. тэгээс их	B. тэгээс бага	C. тэг	D. нэгтэй тэнцүү
--------------	----------------	--------	------------------

11. ТӨЗЗ дээр үйл ажиллагаа явуулдаг пүүсийн тогтмол зардал 100, ахиу зардал нь  $4Q$  байг. 15 бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр ашиг хамгийн их байдаг бол бүтээгдэхүүний үнийг ол  
 A. 60                      B. 160                      C. 450                      D. 550
12. Үйлдвэрлэгчийн эрэлт ба зардлын мэдээлэл зурагт өгөгджээ. Үйлдвэрлэгч ашгаа хамгийн их байлгадаг бол нийт зардлыг тооц.



- A. 3000  
 B. 2500  
 C. 1800  
 D. 1500

13. ТӨЗЗ дээр ажилладаг пүүсийн нийт зардлын функц  $TC=2Q^2+100$  бол бүтээгдэхүүний үнэ 4 байх үеийн нийлүүлэлтийн мэдрэжмийг тооц  
 A. 0.5                      B. 1                      C. 2                      D. 4
14. Урт хугацаанд ТӨЗЗ-ийн пүүс дараах нөхцлийг хангана  
 A.  $P=MR$                       B.  $MR=MC$                       C.  $P=ATC$                       D. Дээрх бүгд
15. Эрэлт ба нийлүүлэлт зэрэг буурсан бол  
 A. Тэнцвэрт хэмжээ гарцаагүй буурсан                      C. Тэнцвэрт үнэ гарцаагүй буурсан  
 B. Тэнцвэрт хэмжээ гарцаагүй өөрчлөгдөөгүй                      D. Тэнцвэрт үнэ гарцаагүй өөрчлөгдөхгүй
16. Пүүсийн хөрөнгө оруулалтын хүлээгдэж буй ашгийн норм буурахад түүний эзэмших хүсэлтэй байгаа капиталын хэмжээ  
 A. Өснө                      B. Буурна                      C. Өөрчлөгдөхгүй                      D. тодорхойлох боломжгүй
17. Монопольт өрсөлдөөнт пүүсийн монопольт пүүсээс ялгаатай тал нь  
 A. Урт хугацаанд эдийн засгийн ашиг олдог  
 B. Эрэлтээс хамааруулан үнээ тогтоодог  
 C. Богино хугацаанд л эдийн засгийн ашиг олдог  
 D. Үнэ тогтоохдоо ашиг хамгийн их байх нөхцлийг хангах ёстой
18. Монопольт өрсөлдөөний зах зээл дээр ажилладаг нэгэн пүүс  $AC=MC=10$  байх үед үйлдвэрлэлээ явуулдаг байв. Бүтээгдэхүүний эрэлтийн функц нь  $Q=30-P$  функцээр өгөгджээ. Яг одоогийн байдлаар пүүс 25 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа. Пүүс ашгаа хамгийн их байлгахын тулд үйлдвэрлэлийн хэмжээгээ яаж өөрчлөх вэ?  
 A. 20 -оор өсгөнө                      C. 15-аар өсгөнө  
 B. 20 -оор бууруулна                      D. 15-аар бууруулна
19. Монопольт үйлдвэрийн хувьд  $MR=160\$$ ,  $MC=120\$$ ,  $ATC=220\$$  үед үйлдвэрлэл явагдаж байгаа бол хамгийн их ашиг олохын тулд  
 A. Үнээ өсгөж, үйлдвэрлэлээ нэмэгдүүлнэ  
 B. Үнээ өсгөж, үйлдвэрлэлээ бууруулна  
 C. Үнийг бууруулж, үйлдвэрлэлээ бууруулна  
 D. Үнийг бууруулж, үйлдвэрлэлээ нэмэгдүүлнэ
20. Хөдөлмөрийн ахиу бүтээгдэхүүнд дараах нөхцлүүдийн аль нь илүү нөлөөлөх вэ?  
 A. Хүмүүн капитал                      C. Технологийн дэвшил  
 B. Нас, хүйсээр ялгаварлан үзэх байдал                      D. А ба С хариултууд зөв
21. Орлогын хуваарилалтыг харуулдаг муруй  
 A. Филиппсийн муруй                      C. Кузнецийн муруй  
 B. Лоренцийн муруй                      D. Кобб-Дугласын муруй
22. Монопольт өрсөлдөөнт зах зээлийн нөхцөлд С хэмжээний үйлдвэрлэл явуулж байгаа пүүс ямар хугацаанд үйл ажиллагаа явуулж байна вэ?




- A. Богино хугацаанд
- B. Урт хугацаанд
- C. МӨЗЗ дээрх пүүсийн үйл ажиллагаанд хугацааны ялгаа гардаггүй
- D. Ямар хугацаанд ажиллаж байгааг тодорхойлоход нэмэлт мэдээлэл хэрэгтэй

23. Монополь үйлдвэрлэгчийн эрэлтийн функц  $Q=100-P$ , зардлын функц  $TC=Q^2 +16$  гэж өгөгджээ. Ашиг хамгийн их байх үеийн үнэ, үйлдвэрлэлийн хэмжээг ол.
- A.  $Q=20, P=80$     B.  $Q=25, P=75$     C.  $Q=30, P=70$     D.  $Q=35, P=65$
24. Ядуурлын түвшинг хэрхэн тооцдогвэ?
- A. Нэн ядуу хүмүүсийн тоог ядуу иргэдийн тоонд харьцуулах
  - B. Ядуу хүмүүсийн тоог ядуу бус хүмүүсийн тоонд харьцуулах
  - C. Ядуурлын шугамын доорх хүмүүсийн тоог нийт хүн амын тоонд харьцуулах
  - D. Нэн ядуу болон харьцангуй ядуу хүмүүсийн тоог ядуу бус хүмүүсийн тоонд харьцуулах
25. Бизнесийн мөчлөгийн сэргэлтийн үе эхлэхэд эдийн засагт дараах өөрчлөлтүүд гарна. Үүнд:
- A. ДНБ-ий өсөлтийн хурд нэмэгдэнэ, ажилгүйдлийн түвшин буурна
  - B. ДНБ-ий өсөлтийн хурд саарна, ажилгүйдлийн түвшин буурна
  - C. ДНБ-ий өсөлтийн хурд нэмэгдэнэ, ажилгүйдлийн түвшин өснө
  - D. ДНБ-ий хэмжээ буурна, ажилгүйдлийн түвшин өснө
26. Хэрэглээний үнийн индекс 2011 онд 225 байсан ба 2012 онд 234 болжээ. Энэ үед нэрлэсэн зээлийн хүү 6.5 хувь байсан бол бодит зээлийн хүү хэдэн хувь байсан бэ?
- A. 2.5    B. 4.0    C. 7.5    D. 10.5
27. Нэгэн эдийн засагт хэрэглэгчид нь зөвхөн талх болон сэтгүүл худалдан авдаг. Тогтмол хэрэглээний сагс нь 30 талх болон 4 сэтгүүлээс бүрддэг. 2011оны 4 сард талх  $\text{₮}1000$  болон сэтгүүл  $\text{₮}5000$  байсан. 2012оны 4 сард талх  $\text{₮}1300$  байв. 2011оны 4 сарыг суурь болгон 2012 оны 4 сард хэрэглээний үнийн индекс 120 болсон бол 2012 оны 4 сард сэтгүүл ямар үнэтэй байсан бэ?
- A. 5000    B. 5250    C. 5300    D. 6000
28. Монгол улсын эдийн засгийн хувьд богино хугацаанд үнийн түвшний өсөлт болон бодит ДНБ-ий бууралтын шалтгаан аль нь вэ?
- A. мөнгөний нийлүүлэлтийн өсөлт
  - B. засгийн газрын зардлын өсөлт
  - C. хувьцааны үнийн уналт
  - D. нефть бүтээгдэхүүний үнийн өсөлт
29. Хүснэгтэд буй мэдээллийг ашиглан энэ улсын ажилгүйдлийн түвшинг тооцоол.
- |         | Ажиллах хүчинд орохгүй насанд хүрсэн хүний тоо | Ажилгүй хүний тоо | Ажиллаж байгаа хүний тоо |
|---------|--|-------------------|--------------------------|
| Эрэгтэй | 45 сая   | 5 сая             | 85 сая                   |
| Эмэгтэй | 35 сая   | 5 сая             | 65 сая                   |
- A. 4.12%    B. 12.5%    C. 11.11%    D. 6.25%
30. Дээрх хүснэгтийн мэдээллийг ашиглавал эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин хэд вэ?
- A. 7.4 %    B. 33.3%    C. 37.03%    D. 66.6%
31. Ихэнх улс орнуудын хувьд өнгөрсөн 50 жилийн хугацаанд бодит ДНБ болон үнийн түвшин нь өсөх хандлагатай байв. Үүний тайлбарыг дараахаас аль нь илэрхийлэх вэ?
- A. зөвхөн технологийн дэвшилээр
  - B. зөвхөн мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөөр
  - C. технологийн дэвшил болон мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөөр тайлбарлана
  - D. дээрхийн аль нь ч бодит ДНБ-ий өсөлт болон инфляцийг тайлбарлаж чадахгүй

32. Өнгөрсөн жилтэй харьцуулахад энэ жил ажилтай хүмүүсийн тоо нэмэгдсэн гэж нэгэн нэр дэвшигч мэдэгджээ. Гэтэл нөгөө нэг нэр дэвшигч харин ч энэ жил ажилгүй хүмүүсийн тоо нэмэгдсэн гэж мэдэгджээ. Эдгээр мэдэгдлийг дараахаас аль нь хамгийн сайн тайлбарлаж чадах вэ?

- A. Эдгээр мэдэгдэл хоёулаа үнэн байх боломжгүй, аль нэг нь худал
- B. Өнгөрсөн жилтэй харьцуулахад ажиллах хүч өссөн
- C. Өнгөрсөн жилтэй харьцуулахад ажиллах хүчний оролцооны түвшин буурсан
- D. Өнгөрсөн жилтэй харьцуулахад ажилгүйдлийн түвшин өссөн

33. Хэрэв хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хэмжээг \$5-оос бол \$6 болгож өсгөсөн бол энэ зах зээл дээр ажилгүйдэл



- A. өөрчлөгдөхгүй
- B. 20-иор нэмэгдэнэ
- C. 40-өөр нэмэгдэнэ
- D. 40-өөр буурна

34. Дээрх графикт өгөгдсөн мэдээлэлд үндэслэн хэрэв хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг \$5-оос бол \$7 болгож өсгөсөн болажилгүйдэл

- A. Өөрчлөгдөхгүй
- B. 20-иор нэмэгдэнэ
- C. 40-өөр нэмэгдэнэ
- D. 40-өөр буурна


35. Хаалттай эдийн засагт нийт татвар нэмэгдэх нь

- A. Үндэсний нийт хадгаламж болон улсын хадгаламжийг өсгөнө
- B. Үндэсний нийт хадгаламж болон улсын хадгаламжийг өөрчлөхгүй
- C. Үндэсний нийт хадгаламж өөрчлөгдөхгүй, улсын хадгаламж буурна
- D. Үндэсний нийт хадгаламж өөрчлөгдөхгүй, улсын хадгаламж өснө.

36. Нийт эрэлт урьдчилан таамаглаагүй ихээр гэнэт буурсан үед:

- A. Үнийн түвшин өснө
- B. Ажилгүйдэл буурна
- C. Бодит ДНБ өснө
- D. Ажилгүйдлийн түвшин өснө

37. Доорх зурагт нийт эрэлт (НЭ), урт хугацааны нийт нийлүүлэлт (УХНН) болон богино хугацааны нийт нийлүүлэлтийн (БХНН) муруйнууд өгөгдсөн байна. Нийт эрэлт, нийт нийлүүлэлтийн тэнцвэр одоогоор  $E^1$  цэгт байгаа бол эдийн засаг нь




- A. Богино хугацааны тэнцвэрт байна
- B. Бүрэн ажил эрхлэлттэй байна
- C. Эдийн засаг хэвийн түвшингөөсөө хэт их өсөлттэй байна
- D. Хэвийн ажилгүйдлийн түвшиндөө байна.

38. Нэгэн жижиг эдийн засагт тооны машиныг 4 доллароор борлуулдаг байв. Тооны машины дэлхийн үнэ 5 доллар бөгөөд энэхүү эдийн засаг олон улсын худалдаанд оролцсон бол

- A. тооны машиныг импортлох ба үнэ 5 доллар болно
- B. тооны машиныг импортлох ба үнэ 4 доллар болно
- C. тооны машиныг экспортлох ба үнэ 5 доллар болно
- D. тооны машиныг экспортлох ба үнэ 4 доллар болно

39. Худалдаагүй үеийн үйлдвэрлэгчийн илүүдлийг аль талбайгаар хэмжих вэ?



- A. A
- B. B+C
- C. A+B+D
- D. D

40. Дээрх графикт үндэслэн худалдаа хийсний дараах хэрэглэгч болон үйлдвэрлэгчийн нийт илүүдлийг тооц.

- A. A + B
- B. A + B + C
- C. B + C + D
- D. A + B + C + D

41. “ЭЗО” банкны дансны мэдээлэл дараах хүснэгтэд өгөгджээ. Нэгэн хүн энэ банкинд 500000 төгрөгийн хадгаламж нээсэн болсон бол энэхүү банкны заавал байлгах нөөц хэд болох вэ?

Актив		Пассив	
Заавал байлгах нөөц	₮30 000	Татан төвлөрүүлсэн хөрөнгө	₮100 000
Зээл	₮70 000		

- A. 150 000
- B. 180 000
- C. 450 000
- D. 500 000

42. Хүснэгтэд өгөгдсөн мэдээллийг ашиглан 2006, 2007, 2008 онуудын нэрлэсэн ДНБ-ий хэмжээг тооц.

Он	Номны үнэ	Номны хэмжээ	Дэвтрийн үнэ	Дэвтрийн хэмжээ
2006	\$4	100	\$2	180
2007	\$5	120	\$2.5	200
2008	\$6	150	\$3.5	200

- A. \$680, \$880, \$1200;
- B. \$760, \$880, \$1000;
- C. \$760, \$1100, \$1600;
- D. \$960, \$1280, \$1300;

43. Дээрх хүснэгтийн мэдээллийг ашиглан 2006 оныг суурь он болгож авбал 2007 оны хувьд

- A. Бодит ДНБ нь \$880, ДНБ-ий дефлятор нь 80
- B. Бодит ДНБ нь \$880, ДНБ-ий дефлятор нь 125
- C. Бодит ДНБ нь \$950, ДНБ-ий дефлятор нь 95
- D. Бодит ДНБ нь \$950, ДНБ-ий дефлятор нь 116

44. Мөнгөний бодлого нь ажил эрхлэлтэнд

- A. Зөвхөн богино хугацаанд нөлөөлнө
- B. Зөвхөн урт хугацаанд нөлөөлнө
- C. Аль ч хугацаанд нөлөөлнө
- D. Ямар ч хугацаанд нөлөөгүй

45. 2012 онд А улсын ДНБ нь 2500 ам.доллар бөгөөд жилд дунджаар 2 хувиар өсдөг. Харин Б улсын ДНБ нь жилд дунджаар 4 хувиар өсдөг. Энэ 2 улсын ДНБ нь 35 жилийн дараа тэнцүү болох бол 2012 оны Б улсын ДНБ-ийг ол?

- A. 5000 ам.доллар
- B. 2500 ам.доллар
- C. 1250 ам.доллар
- D. 625 ам.доллар

46. Батсүрэн 2005 онд 60 сая төгрөгийн үнэтэй шинэ байр худалдан авч амьдарч байгаад 2006 онд түүнийгээ 95 сая төгрөгөөр зарсан бол дараах тайлбаруудын аль нь зөв бэ?

- A. 2006 оны худалдаа нь 2006 оны ДНБ-г 95 саяар нэмэгдүүлсэн бөгөөд 2005 оны ДНБ-д нөлөө үзүүлэхгүй
- B. 2006 оны худалдаа нь 2006 оны ДНБ-г 35 саяар нэмэгдүүлсэн бөгөөд 2005 оны ДНБ-д нөлөө үзүүлэхгүй
- C. 2006 оны худалдаа нь 2006 оны ДНБ-г нэмэгдүүлэхгүй бөгөөд 2005 оны ДНБ-г 35 саяар нэмэгдүүлнэ
- D. 2006 оны худалдаа нь 2005 болон 2006 оны ДНБ-д нөлөө үзүүлэхгүй

47. А улсын хүн ам жилд 1 хувиар өсдөг ба Б улсын хүн ам 2 хувиар өсдөг. Энэ хоёр улсын нэг хүнд ногдох ДНБ нь тэнцүү бөгөөд жил бүр ижилхэн хурдаар өсдөг бол А улсын нэг хүнд ногдох ДНБ нь 35 жилийн дараа Б улсынхаас хэд дахин их байх вэ?
- А. 2 дахин                      В. 4 дахин                      С. Тэнцүү                      D. Хэлэх боломжгүй
48. 2000 онд нэгэн улсын нэрлэсэн ДНБ-ий өсөлт 8% ба инфляцийн түвшин 4% байсан. Энэ улсын бодит ДНБ-ий өсөлтийг ол?
- А. -4%                              В. 2%                              С. 4%                              D. 8%
49. Бусад хүчин зүйл тогтмол байхад дараах хүчин зүйлсийн аль нь төгрөгийн ханшийг унагах вэ?
- А. Монгол Улсын орлогын өсөлт худалдааны түншүүдийнхээсээ удаан байх  
 В. Худалдааны түнш улсуудаас доогуур инфляцитай байх  
 С. Монголын эдийн засгийн ирээдүйд итгэл буурснаас бий болох капиталын гадагшлах урсгал  
 D. Монголын нүүрсийг худалдан авах Хятадын эрэлт өсөх
50. Орлогын хуваарилалт дараах байдлаар өгөгджээ. 2000 оныг 2010 онтой харьцуулахад орлого хуваарилалт

Иргэд	Орлого 2000	Орлого 2010
1	100	100
2	100	100
3	100	300
4	200	500
5	500	1000
Нийт	1000	2000

- А. Сайжирсан  
 В. Муудсан  
 С. Хэвэндээ  
 D. Хэлэх боломжгүй